

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 5 дугаар сарын 10-ны өдөр

№ 19/30

Улаанбаатар хот

Их хэмжээний хэлцэл хийх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.4, 80.7 дахь заалт, 87 дугаар зүйл, 88 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.19, 9.10, 9.11 дэх заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээс ирүүлсэн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Гадаад валютын ханшийн эрсдлийг удирдах зорилгоор Худалдаа Хөгжлийн Банк (“Банк”)-нд 5,000,000 (таван сая) хүртэлх хэмжээний АНУ-ын долларыг хадгаламжийн данс нээж, байршуулах, уг хадгаламжаа барьцаалан, энэхүү тогтоолын 1 дүгээр Хавсралтад заасан нөхцөлийн хүрээнд байршуулсан хадгаламжийн дүнгийн 110 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн зээл авах, Зээлийн болон холбогдох бусад гэрээ, хэлцэл байгуулах, тэдгээрт гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д олгосугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт зааснаар Худалдаа Хөгжлийн Банктай байгуулсан Зээлийн гэрээний нөхцөлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дараагийн ээлжит хуралд эргэн танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



..... /О.БОЛДБААТАР/

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

..... /С.БОРГИЛ/

..... /В.БАЯРСАЙХАН/

..... /Ж.ЖАРГАЛСҮРЭН/

..... /MATHEW WELCH/

..... /Ч.НОМИН/

..... /Н.ЦЭВЭГМИД/

..... /С.ЭНХ-АМГАЛАН/

..... /Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2019 оны 19/20 дугаар тогтоолын ХАВСРАЛТ



**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКТАЙ ХИЙХ ХАДГАЛАМЖ БАРЬЦААЛЖ
ЗЭЭЛ АВАХ ХЭЛЦЛИЙН НӨХЦӨЛ**

	Нөхцөл
Хадгаламжийн хэмжээ	5,000,000 хүртэл ам.доллар
Хугацаа	6, 12 сар
Хадгаламжийн валют	АНУ-ын доллар (ам.доллар)
Хадгаламжийн хүү (жил, доод хувь)	6 сар 3.2% 12 сар 5.4%
Зээлийн валют	Төгрөг
Зээлийн дүн	[Байршуулсан хадгаламжийн үнийн дүн x 110% x Зээлд хөрвүүлэх ханш]
Зээлийн хүү (жил, дээд хувь)	14.4%
Нэмэлт барьцаа	ЛэндМН ББСБ ХК-ийн хэвийн ангилалтай зээлийн багц, харилцах дансны орлого
Нэмэлт барьцааны дүн	[(Зээлийн дүн-Байршуулсан хадгаламжийн дүн) x 2] дүнтэй тэнцэх үнийн дүн бүхий зээлийн багц
Төгрөгийн зээлийн хэмжээ тооцоход баримтлах ханш	1 USD = 2,600 MNT (Банкнаас өөрчлөн тогтоосон тохиолдолд түүнийг мөрдөнө)

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 5 дугаар сарын 10-ны өдөр

№ 19/31

Улаанбаатар хот

Их хэмжээний хэлцэл хийх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.4, 80.7 дахь заалт, 87 дугаар зүйл, 88 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.19, 9.10, 9.11 дэх заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээс ирүүлсэн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Гадаад валютын ханшийн эрсдлийг удирдах зорилгоор Капитрон Банк (“Банк”)-нд 3,000,000 (гурван сая) АНУ-ын доллар хүртэлх хэмжээний ам.долларыг хадгаламжийн данс нээж, байршуулах, уг хадгаламжаа барьцаалан, энэхүү тогтоолын 1 дүгээр Хавсралтад заасан нөхцөлийн хүрээнд Банктай харилцан тохиролцсон нөхцөлөөр зээл авах, Зээлийн болон холбогдох бусад гэрээ, хэлцэл байгуулах, тэдгээрт гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д олгосугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт зааснаар Капитрон Банктай байгуулсан Зээлийн гэрээний нөхцөлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дараагийн ээлжит хуралд эргэн танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



..... /О.БОЛДБААТАР/

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

..... /С.БОРГИЛ/

..... /В.БАЯРСАЙХАН/

..... /Ж.ЖАРГАЛСҮРЭН/

..... /MATHEW WELCH/


..... /Ч.НОМИН/

..... /Н.ЦЭВЭГМИД/

..... /С.ЭНХ-АМГАЛАН/

..... /Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2019 оны 19/3 дугаар тогтоолын ХАВСРАЛТ



**КАПИТРОН БАНКТАЙ ХИЙХ ХАДГАЛАМЖ БАРЬЦААЛЖ ЗЭЭЛ АВАХ
ХЭЛЦЛИЙН НӨХЦӨЛ**

	Нөхцөл
Хадгаламжийн хэмжээ	3,000,000 ам.доллар хүртэл
Хугацаа	6, 12 сар
Хадгаламжийн валют	АНУ-ын доллар (ам.доллар)
Хадгаламжийн хүү /жил, доод хувь/	1.0%
Зээлийн валют	Төгрөг
Зээлийн хэмжээ	Байршуулсан хадгаламжийн үнийн дүнгийн 80%-аас багагүй ам.доллартай тэнцэх төгрөг
Зээлийн хүү /жилийн/	Хадгаламжийн хүү + 6.5%
Төгрөгийн зээлийн хэмжээ тогтооход баримтлах ханш	Зээлийн гэрээ байгуулах өдрийн Монголбанкнаас зарласан Ам.долларын ханш
Нэмэлт барьцаа	Байхгүй

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 5 дугаар сарын 10-ны өдөр

№ 19/32

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.4, 80.7 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1.1 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.2, 9.6.20, 9.11, 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.4, 20.5, 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журмын 11.8, 11.12 дахь заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 19/12 тоот тогтоол, уг тогтоолын 1 дүгээр Хавсралтаар батлагдсан ЛэндМН ББСБ ХК-ийн “Эх үүсвэрийн 2019 оны төлөвлөгөө”-г тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Компанийн ТУЗ-ийн 2019 оны 1 сарын 30-ны өдрийн 19/12 тоот тогтоолоор эрх олгосныг үндэслэн Эх үүсвэрийн 2019 оны төлөвлөгөөний дагуу 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдөр хүртэлх хугацаанд гаргасан дараах нөхцөлтэй хаалттай өрийн бичиг болон Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-ын байгуулсан Хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээг хүлээн зөвшөөрч, баталсугай.
 - 1) **Нийт үнэ:** 883,000,000 (найман зуун наян гурван сая) төгрөг;
 - 2) **Хугацаа:** 1 (нэг) жил;
 - 3) **Хүү:** жилийн 16.0 (арван зургаа) - 17.0 (арван долоо) хувь;
 - 4) **Хүү төлөх хугацаа:** 3 сар, эсхүл 6 сар тутам;
 - 5) **Барьцаа, баталгаа:** Байхгүй;
 - 6) **Хугацаанаас өмнө буцаан худалдан авах:** Компани нь өрийн бичгийг Хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээнд заасан нөхцөлөөр хугацаанаас нь өмнө буцаан худалдан авах эрхтэй.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан нөхцөл бүхий хаалттай бондыг гаргах зорилгоор “Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК” ХХК-тай 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдөр байгуулсан 2019/95 тоот Андеррайтерийн гэрээ болон тус гэрээний дагуу гаргасан хаалттай өрийн бичгийн дүнгийн 2 (хоёр) хувьтай тэнцэх шимтгэлийг тус компанид төлсөн үйлдлийг хүлээн зөвшөөрч, баталсугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

..... /О.БОЛДБААТАР/

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

..... /С.БОРГИЛ/

..... /Ж.ЖАРГАЛСҮРЭН/

..... /Ч.НОМИН/

..... /С.ЭНХ-АМГАЛАН/

..... /В.БАЯРСАЙХАН/

..... /MATHEW WELCH/

..... /Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 5 дугаар сарын 10-ны өдөр

№ 19/33

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.4, 80.7 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1.1 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.20, 9.11, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журмын 11.8, 11.12 дахь заалтыг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Компанийн ТУЗ-ийн 2019 оны 1 сарын 30-ны өдрийн 19/12 тоот тогтоолоор эрх олгосныг үндэслэн Компанийн Эх үүсвэрийн 2019 оны төлөвлөгөөний дагуу Итгэлцлийн үйлчилгээгээр хөрөнгө татан төвлөрүүлэх зорилгоор “Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК” ХХК-тай байгуулсан 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 2019/274 тоот Зөвлөх үйлчилгээний гэрээ болон тус гэрээний дагуу зөвлөх үйлчилгээний хөлсийг тус компанид төлсөн үйлдлийг зөвшөөрч, баталсугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:

..... /О.БОЛДБААТАР/

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

..... /С.БОРГИЛ/

УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

..... /В.БАЯРСАЙХАН/

..... /Ж.ЖАРГАЛСҮРЭН/

..... /MATHEW WELCH/

..... /Ч.НОМИН/

..... /Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

..... /С.ЭНХ-АМГАЛАН/

ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 5 дугаар сарын 10-ны өдөр

№ 19/34

Улаанбаатар хот

Хэлцэл хийх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16, 76.1.17 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.4, 80.7 дахь заалт, 87 дугаар зүйлийн 87.1 дэх заалт, 88 дугаар зүйлийн 88.1, 89 дүгээр зүйлийн 89.1.1 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.2, 9.6.19, 9.6.20, 9.11, 19 дүгээр зүйлийн 19.1.1, 19.2 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.8.2, 11.8, 11.12 дахь заалтыг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан “Эх үүсвэрийн 2019 оны төлөвлөгөө”-ний хүрээнд Итгэлцлийн үйлчилгээ болон Хаалттай хэлбэрээр гаргасан өрийн бичгийг боломжит хөрөнгө оруулагчдад санал болгоход “Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК” ХХК-тай хамтран ажиллах, Зөвлөх үйлчилгээний болон Андеррайтерын гэрээ байгуулах, гэрээнд заасан нөхцөлийн дагуу холбогдох хөлсийг төлөхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

ТУЗ-ИЙН ДАРГА:
..... /О.БОЛДБААТАР/

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

..... /С.БОРГИЛ/

..... /В.БАЯРСАЙХАН/

..... /Ж.ЖАРГАЛСҮРЭН/

..... /MATHEW WELCH/

..... /Ч.НОМИН/

..... /Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

..... /О.ЭНХ-АМГАЛАН/

УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206